# “Хатанцацал” ХХК-ийн Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт орших MV-011969 тоот ашиглалын тусгай зөвшөөрөл бүхий “Шарга-Овоо нэртэй алтны үндсэн ордыг ил, далд аргаар ашиглах” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**РД: 5061989**

**УЛААНБААТАР ХОТ 2026 ОН**

# БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 1.1 Төслийн талаарх мэдээлэл

Хүснэгт 1.Төслийн ерөнхий мэдээлэл

| | | |
|---|---|---|
| Нэг. Ерөнхий мэдээлэл | | |
| 1.1 | Төсөл хэрэгжүүлэгч: | “Хатанцацал” ХХК РД: 5061989 УБД: 9011822410 |
| 1.2 | Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороолол, их монгол улс, стадион оргил, 407,1401 тоот<br>Утас: 99112488 |
| 1.3 | Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл | Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт орших Шарга-Овоо нэртэй алтны үндсэн ордын 463 га талбай бүхий MV-011969 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг 30 жилийн хугацаатай 2006.08.30-ны өдөр АМГТГХЭГ-ын Геологи уул уурхайн кадастрын албаны даргын “Хатанцацал” ХХК-д олгосон. |
| Хоёр. Төслийн талаарх мэдээлэл | | |
| 2.1 | Төслийн нэр | “Шарга-Овоо нэртэй алтны үндсэн орлыг ил, далд аргаар ашиглах” төсөл |
| 2.2 | Төсөл хэрэгжих байршил: | Төслийн талбай нь Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш 270 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос баруун зүгт 70 км, Эрдэнэдалай сумын төвөөс (Сангийн далай) баруун хойш 20 км зайд байрлана. Монгол орны 1:100000 масштабтай L-48-66 тоот хавтгайд хамрагддаг.<br><br>Тусгай зөвшөөрлийн талбайгаас хамгийн ойр орших малчин айл нь 423 м-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105:2001 стандартын шаардлагыг хангахгүй байна.<br><br> |

| | | |
|---|---|---|
| 2.3 | Ордын нөөц | Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц магадалсан B’ зэргээр 104.34 мян.тн хүдэр, хүдэр дэх металлын хэмжээ 260.09 мян.тн (дундаж агуулга 2.49 гр/тн) байна.<br>Далд уурхайн үйлдвэрлэлийн нөөц магадалсан B’ зэргээр 30.27 мян.тн хүдэр, хүдэр дэх металлын хэмжээ 85.73 кг (дундаж агуулга 2.83 гр/тн) байна. |
| 2.3 | Төслийн хүчин чадал | Ил уурхйн хүчин чадал: Ашиглалтын 2 жилийн хугацаанд 1200 мян.м3 хөрс хуулалт хийж 55 мян.тн хүдэр олборлоно. Ил уурхайн нь 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр 210 хоног ажиллана.<br>Далд уурхйн хүчин чадал: Далд уурхайг 1 жил ашиглах бөгөөд 30.27 мян.тн хүдэр олборлоно. Далд уурхай нь 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр 300 хоног ажиллана.<br>Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал: Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал нь жилд 60.0 мянган тонн, хоногт 285.7 тонн, цагт 13.2 тонн хүдэр боловсруулна. Баяжуулах үйлдвэр нь нийт 3 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулах бөгөөд нэг жилд дунджаар 240 хоног ажиллахаар төлөвлөгдсөн |
| 2.4 | Төсөл хэрэгжих хугацаа | Ил уурхай: 2 жил<br>Далд уурхай: 1жил<br>Нийт 3 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулна. |
| 2.4 | Баяжуулах үйлдвэрийн технологи |  |
| 2.5 | Төслийн хог хаягдал | Хатуу хог хаягдал:<br>Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор жилд 30.7-52.1 тн орчим хаягдал гарах бөгөөд харьяа сум, багийн холбогдох байгууллага /ТҮК/-тай гэрээ |

байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэдэг байна.

Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.

- Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт

Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд

- Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал

/ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна.

Доорхи зургийн дагуу ялгаж хаях шаардлагатай




Шингэн хог хаягдал:

Нийт 170-202 ажилтантай гэж үзвэл хоногт 25.5-30.3 м3, жилд 5355-9090 м3 усыг унд ахуйн усны хэрэглээнд ашилана.

Хийн хаягдал:

Үйлдвэрийн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.

Үйлдвэрийн ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт 1481.7 тн /жилд 493.9 тн/ дизель түлш зарцуулахад хөө – 22.96 тн, CO-0.000148 тн, нүүрстөрөгч–0.000445 тн, NO2–

0.00005927 тн, SO2-0.00002963тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 22.96 тн хаягдал хий ялгарахаар байна.

**1.3 Төслийн байршил**

Тусгай зөвшөөрлийн талбай нь Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш 270 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос баруун зүгт 70 км, Эрдэнэдалай сумын төвөөс (Сангийн далай) баруун хойш 20 км зайд байрлана. Монгол орны 1:100000 масштабтай L-48-66 тоот листэд хамрагддаг. Ашиглалтын тусгай зөвшөөрөл 463 га талбайтай.




Зураг 1. Засаг захиргааны зураг



Зураг 2. MV-011969 тоот тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг

Хүснэгт 2.  MV-011969 тоот тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд

| Д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | град | мин | сек | град | мин | Сек |
| 1 | 104 | 59 | 21.06 | 46 | 10 | 11.66 |
| 2 | 104 | 57 | 01.05 | 46 | 10 | 11.66 |
| 3 | 104 | 57 | 01.05 | 46 | 11 | 01.66 |
| 4 | 104 | 59 | 21.06 | 46 | 11 | 01.66 |



Зураг 3. Төслийн талбайн харагдах байдал



Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн харагдах байдал



Зураг 5. Бичил уурхайчдын олборлон эвдрэлд өртсөн талбай



Зураг 6. Кемпийн харагдах байдал

## 1.3 Төслийн хүчин чадал, ажиллах горим

Ил уурхайн хүчин чадал: Ашиглалтын 2 жилийн хугацаанд 1200 мян.м3 хөрс хуулалт хийж 55 мян.тн хүдэр олборлоно.  Ил уурхайн нь 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр 210 хоног ажиллана.

Далд уурхайн хүчин чадал: Далд уурхайг 1 жил ашиглах бөгөөд 30.27 мян.тн хүдэр олборлоно. Далд уурхай нь 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр 300 хоног ажиллана. Ашиглалтын II жилээс ил уурхайн ашиглалтын үйл ажиллагаатай зэрэгцэн далд уурхайн малталт нэвтрэлт, бэлтгэл ажлыг эхлүүлэн, ашиглалтын III жилд хүдэр олборлолтын ажил болон уурхайг хаах, нөхөн сэргээх, суурин болон зөөврийн техник, тоног төхөөрөмжүүдийг хураах, барилга байгууламжуудыг буулгах зэрэг ажлууд шат дараалалтайгаар хийгдэх тул нийт ажиллах хугацааг 3 жил байхаар тооцсон.

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал: Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал нь жилд 60.0 мянган тонн, хоногт 285.7 тонн, цагт 13.2 тонн хүдэр боловсруулна. Баяжуулах үйлдвэр нь нийт 3 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулах бөгөөд нэг жилд дунджаар 240 хоног ажиллахаар төлөвлөгдсөн.

**1.4 Төслийн тоног төхөөрөмж, технологийн шийдэл**

Ил уурхайн технологийн шийдэл

Тус ордын хөрс хуулалт болон хүдэр олборлолтын ажлыг авто тээвэртэй гадаад овоолготой ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэнэ. Ордын бодитой (B) ба боломжтой (C) нөөцийг олборлохоор 1400 м-ийн түвшин хүртэл ил уурхайгаар хүдрийн биетийн уналын дагуу дээрээсээ доош гэсэн ерөнхий чиглэлтэй, хүдрийн биетийн суналын дагуу уулын ажлын ахилттайгаар гүйцэтгэнэ.

Шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2 м-ээс ихгүй зузаантайгаар шууд утгуурт ачигчаар түрж, хутган автосамосвалд ачин ил уурхайн үржил шимт хөрсний гадаад овоолгод байрлуулна. Шимт хөрсийг хөрс хуулалтын хослол болох 3.0 м3-ын утгуурын багтаамжтай утгуурт ачигч 36.0 тн даацтай автосамосвалын хослолоор хуулна. Шимт хөрсийг ил уурхайн эцсийн хүрээний гадна зүүн урд талд 400 м зайд зөөвөрлөн овоолно. Өрнөлтгүй болсон овоолго, уурхайн бүрэн ашиглагдсан газарт техникийн нөхөн сэргээлт хийсний дараа шимт хөрсөөр хучна. Ирээдүйд уулын ажилд өртөх талбайн шимт хөрсийг хуулж, шууд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газарт ашиглах боломжтой.

Хөрс хуулалтын ажил: Хөрсний чулуулгийг хуулахдаа урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараа хөрсний гадаад овоолгод шилжүүлнэ. Хөрс хуулалтын ажилд 3.0 м3 утгуурын багтаамжтай урвуу утгуурт гидравлик экскаватор, 36.0 тн даацтай автосамосвалууд тус тус ажиллана.

Хүдэр олборлолт: Хөрсний доголтой нэгэн адил хүдэр олборлолтын догол нь 5 м өндөртэй байна. Хүдэр олборлолтод 3.0 м3 утгуурын багтаамжтай урвуу утгуурт гидравлик экскаватор, 36.0 тн даацтай автосамосвалын хослолоор ажиллана.

Хүснэгт 3. Ил уурхайн календарчилсан төлөвлөгөө

| № | Ашиглалтын жил | Хүдэр | | Агуулга | Металл | Хөрс | Кхх | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мян.м3 | мян.тн | гр/тн | кг | мян.м3 | м3/м3 | м3/тн |
| 1 | I | 19.67 | 53.11 | 2.07 | 109.95 | 585.0 | 29.74 | 11.01 |
| 2 | II | 18.97 | 51.23 | 2.93 | 150.14 | 615 | 32.41 | 12.01 |
| 3 | Нийт | 38.65 | 104.34 | 2.49 | 260.09 | 1200.0 | 31.05 | 11.50 |



Зураг 7. Ашиглалтын II жилийн дараах байдлын дэвсгэр зураг

Овоолго: Тус уурхайгаас хуулсан хөрсийг авто тээврээр тээвэрлэн уурхайн урд талд гадаад овоолгод байршуулна. Ил уурхайгаас ашиглалтын нийт хугацаанд 1200.0 мян.м3 хөрс хуулна. Далд уурхайн малталт нэвтрэлтээс нийт 3.5 мян.м3 хөрс гадаад овоолгод байршина.

Хөрсний гадаад овоолгын дундаж өндөр 12.5-13.7 м, ил ба далд уурхайгаас нийт 1204.5 мян.м3 хөрс гадаад овоолгод байрлах ба гадаад овоолгын эзлэхүүн эцсийн байдлаар сийрэгжилт тооцсоноор 1564.0 мян.м3 байна. Уурхайн олборлолт болон баяжуулах үйлдвэр, барилга байгууламжийн бүтээн байгуулалтад өртөх талбайн шимт хөрсийг хуулж ил уурхайн №1-ийн зүүн урд талд 3.0 метр өндөртэйгээр 68.3 мян.м3 эзэлхүүнтэй шимт хөрсний овоолго байгуулна.

Хүснэгт 4. Овоолгын үндсэн үзүүлэлт

| № | Овоолгын нэр | Хэмжих нэгж | Тоон утга |
|---|---|---|---|
| 1 | Үржил шимт хөрсний овоолго | мян.м3 | 68.3 /2.3 га/ |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Хөрсний гадаад овоолго №1 | мян.м3 | 804.0 /5.85 га/ |
| | Хөрсний гадаад овоолго №2 | мян.м3 | 760.0 /6.1 га/ |
| 3 | Овоолгын өндөр /дунджаар/ | м | 12.5-13.7 |
| 4 | Овоолгын хамгийн их өндөр | м | 20 |
| 5 | Овоолгын налуу | градус | 38 |

**Уулын үндсэн техник, тоног төхөөрөмжүүд**

Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллана.

Хүснэгт 5. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд

| № | Тоног төхөөрөмж | Гүйцэтгэх ажил | Марк | Хүчин чадал | Тоо хэмжээ | Зураг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өрмийн машин | Өрөмдлөг | ZT-44 | 100-200 мм | 2 |  |
| 2 | Экскаватор | Хөрс хуулалт, хүдэр олборлолт | PC-600 | 3.0 м3 | 2 |  |
| 3 | Автосамосвал | Хөрс хуулалт | HD325 | 36 тн | 4 |  |
| 4 | | Хүдэр олборлолт | HD325 | 36 тн | 1 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | Бульдозер | Овоолго | WD-600 | | 1 |  |
| 6 | Утгуурт ачигч | БҮ | WA380-6 | 3.0 м3 | 1 |  |
| 7 | | Туслах ажил | WA380-6 | | 1 | |
| 8 | Грейдер | Туслах ажил | GD-555 | 3.7 м | 1 |  |

Далд уурхайн технологийн шийдэл

Далд уурхайн нээлт:

Босоо гол ам: I хүдрийн биет нь I-C-1 ба I-C-2, I-C-3, I-C-4, I-C-5 гэсэн хоорондоо 40 м зайтай байрлах хоёр хэсгээс бүрдэнэ. Тус далд уурхайг үндсэн хоёр түвшинд хувааж олборлох ба 1369, 1342 м-ийн түвшний хүдрийг босоо гол амаар нээж олборлоно.

I-C-2, I-C-3, I-C-4, I-C-5 блокуудыг ашиглах далд уурхайн босоо гол ам №1-ийг хүдрийн биетийн хэвтээ талд, нурлын бүсийн хүрээний гадна 20-25 м зайд газрын гадаргын X-5114280.5, Y-497468.8, Z-1449 м-ийн солбицлоос дээрээс доош чиглэлд 1349 м-ийн түвшин хүртэл нэвтэрнэ. Босоо гол амнаас хүдрийн биетийн суналд перпендикуляраар квершлаг малталт нэвтэрнэ. Квершлаг малталтаас хүдрийн биетийн хэвтээ талд суналтын дагуу штрек малталт нэвтрэх ба штрек малталтаас хүдрийн биетийн суналд перпендикуляраар орт малталтуудыг 50-55 м-ийн зайтай нэвтэрч хүдрийн биетийг нээнэ.

I-C-1 блокийг ашиглах далд уурхайн босоо гол ам №2-ыг ил уурхайн ёроолын X-5114241.5, Y-497336.1, Z-1415 м-ийн солбицлоос дээрээс доош чиглэлд 1365 м-ийн түвшин хүртэл нэвтэрнэ. Босоо гол амнаас хүдрийн биетийн суналын дагуу 30 м квершлаг малталт нэвтэрнэ. Квершлаг малталтаас хүдрийн биетийн хэвтээ талд суналын дагуу штрек малталт нэвтрэх ба штрек малталтаас хүдрийн биетийн суналд перпендикуляраар орт малталтуудыг 40 м-ийн зайтай нэвтэрч хүдрийн биетийг нээнэ.

Шпурын цэнэгийн аргаар нураах: Тус далд уурхайн хүдрийг шпурын цэнэгийн аргаар нураана. Хүдэр нураалтын ажлыг далд уурхайн ээлжийн хүчин чадалтай уялдуулан нэг ээлжид гурван мөргөцөгт өрөмдлөг тэсэлгээний ажлыг хийнэ. Хүдрийг нураах мөргөцөг нь хүдрийн биетийн зузаанаас хамаарч урт нь дунджаар 2.0 м, өргөн нь 2.0 м мөргөцгийн ахилтыг 1.6 м байхаар тооцов.

Хүдэр нураалтын ажлын технологи: Өрөмдлөгийн ажлыг 2-4 хүний бүрэлдэхүүнтэйгээр гар перфератораар ӨТА-ын паспортын дагуу хийж гүйцэтгэнэ. Шпур өрөмдөж дуусаны дараа ээлжийн мастерын зөвшөөрлийн дагуу тэсрэх материалыг авчирч шпурыг цэнэглэж бусад мөргөцгөөс хүмүүсийг гаргаж тэсэлгээний ажлыг явуулна. Тэсэлгээний ажлын дараа уурхайн ээлжийн мастер, тухайн ээлжийн ахлагчийн хамт агааржуулалтын байдлыг, таазны цохиулыг шалгана.

Далд уурхайн уулын цулыг тээвэрлэх тоног төхөөрөмж: Далд уурхайн хүдэр олборлолт, малталт нэвтрэлтээс гарах уулын цулын хэмжээ зэргээс хамааруулан хүдэр болон хоосон чулуулгийг тээвэрлэхэд 0.55 м3 тэвшний багтаамжтай KFU-0.55 маркийн тэргэнцэр, Z17-AW маркийн ачигч, CJY-3 маркийн цахилгаан зүтгүүр хэрэглэнэ. Хүдэр ба хоосон чулуулгийг тээвэрлэх тэргэнцрийн овор хэмжээ, хүн болон материал тээвэрлэлт зэргийг харгалзан нэг давхар 1КН1.4-1 маркийн клеть, JMD-3T маркийн өргөх төхөөрөмж ашиглахаар сонгосон.

Далд уурхайн ус таталт: Тус ордын хайгуулын ажлын явцад 150 м хүртэл гүнд цооногууд өрөмдсөн ба уст давхарга, үе илрээгүй ч далд уурхайн аваарын горимд ажиллуулах зорилгоор уурхайн хэмжээнд нийт 2 ширхэг ЦНС-13-140 маркийн усны шахуурга шаардлагатай, үүнээс 1 ширхэг нь нөөцөд байна. Гүний усыг үндсэн малталтаар дамжуулан босоо гол амны дэргэд тухайн жилийн ашиглалтын хамгийн доод түвшинд байрлах ус цуглуулах зумпфэнд цуглуулан ЦНС-13-140 маркийн усны шахуургын тусламжтайгаар 125 мм-н диаметртэй төмөр хоолойгоор дамжуулан газрын гадаргууд гаргахаар төлөвлөв. Энэ ус цуглуулах зумпф нь 374 м3-ийн багтаамжтай байна. Малталт нэвтрэлт болон хүдэр нураалтын үед ажиллах өрмийн төхөөрөмжүүдэд шаардлагатай усны хэрэгцээг хангаж ажиллана.

**Баяжуулах үйлдвэрийн технологийн шийдэл**

Технологийн туршилтын үр дүнд тулгуурлан алтны хүдрийг гравитаци – уусгалт хосолсон аргаар баяжуулах технологийг сонгож, технологийн холбогдох тооцооллыг хийж гүйцэтгэсэн.

Уурхайгаас олборлосон хүдрийг баяжуулах үйлдвэрт буталж нунтаглан, том ширхэглэлтэй алт агуулсан хэсгийг төвөөс зугтах хүчний кнельсон сепараторт баяжуулж, баяжмалыг сэгсрэх ширээгээр гүйцээн баяжуулж шлихийн алт агуулсан баяжмалыг гарган авч, алт цэвэршүүлэлт, хайлуулалтын хэсэгт цэвэршүүлнэ. Гравитацийн аргаар баяжуулах боломжгүй жижиг ширхэгтэй алтыг натрийн цианидын уусмалаар уусган баяжуулж алтан гулдмай үйлдвэрлэнэ.




Зураг 8. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн холболтын зураг

**Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалтын тооцоо**

Төслийн нийт хугацаанд 2.57 гр/тн дундаж агуулгатай 134.62 мян.тн хүдрийг гравитаци-уусгалтын хосолсон аргаар баяжуулан 92.76-ийн металл авалттайгаар 320.78 кг алт үйлдвэрлэн, 134.6 мян.тн хаягдал хаяна.

Хүснэгт 6. Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Ашиглалтын жилүүд | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | I жил | II жил | III жил | Нийт |
| Анхдагч хүдэр | | | | | | |
| 1 | Баяжуулах хүдрийн хэмжээ | мян.тн | 20.00 | 60.00 | 54.62 | 134.62 |
| 2 | Хүдэр дэх алтны агуулга | гр/тн | 2.07 | 2.46 | 2.88 | 2.57 |
| 3 | Хүдэрт агуулагдах алтны хэмжээ | кг | 41.40 | 147.35 | 157.07 | 345.82 |
| Алтан гулдмай | | | | | | |
| 4 | Алтны металл авалт | % | 92.76 | 92.76 | 92.76 | 92.76 |
| 5 | Технологиос авах нийт алтны хэмжээ /хими цэврээр/ | кг | 38.40 | 136.68 | 145.70 | 320.78 |
| Хаягдал | | | | | | |
| 6 | Хаягдал хүдрийн хэмжээ | мян.тн | 20.0 | 60.0 | 54.6 | 134.6 |
| 7 | Хаягдал хүдэр дэх алтны агуулга | гр/тн | 0.15 | 0.18 | 0.21 | 0.19 |
| 8 | Хаягдал хүдэр дэх алтны хэмжээ | кг | 3.00 | 10.67 | 11.37 | 25.04 |
| 9 | Алтны металл алдалт | % | 7.24 | 7.24 | 7.24 | 7.24 |

**Баяжуулах үйлдвэрт хэрэглэгдэх тоног төхөөрөмж**

Баяжуулах үйлдвэр нь үндсэн 1 шугамтай ба цагийн хүчин чадал 13.2 тн/ц. Хүдэр баяжуулах технологийн хувьд хяналтын шигшилттэй 2 шатны бутлалт, хяналтын ангилалттай 2 шатны нунтаглалт, гравитацын баяжуулалт, өтгөрүүлэлт, уусгалт шингээлтийн хэсэг, десорбци-электролизийн хэсэг, хайлуулалтын хэсэг, урвалж бэлтгэх хэсэг, хаягдал усгүйжүүлэх хоргүйжүүлэх хэсэг, засвар үйлчилгээний хэсэг, эргэлтийн усны сан, цэвэр усны худаг, ус дамжуулах насос, хяналтын лаборатори зэргээс бүрдэнэ.

Хүснэгт 7. Хацарт бутлуурын техникийн үзүүлэлт

| № | Үндсэн үзүүлэлтүүд | Тоон утга |
|---|---|---|
| 1 | Тоног төхөөрөмжийн марк | PE500*750 |
| 2 | Хүдэр орох амсрын хэмжээ | 500*750 |
| 3 | Хамгийн том ширхэглэлийн хэмжээ, мм | 425 |
| 4 | Хүчин чадал, тн/цаг | 40-90 |
| 5 | Гарах амсрын хэмжээ, мм | 50-100 |
| 6 | Хөдлөх голын хурд, эрг/мин | 275 |
| 7 | Суурилагдсан чадал, кВт | 55 |
| 8 | Нийт жин, тн | 5.8 |
| 9 | Хэрэглэгдэх тоо, шир | 1 |




**Хаягдлын аж ахуй:**

Шарга-Овоогийн алтны үндсэн ордын хүдрийг гравитаци-уусгалтын хосолсон технологиор баяжуулахаар сонгосон бөгөөд хоргүйжүүлэлтээс гарах хаягдлыг усгүйжүүлж 12-15%-ийн чийглэг бүхий шүүгдсэн хуурай хаягдал хаяхаар төлөвлөсөн. Хаягдал хадгалах талбайн далангийн барилга

байгууламж, геотехникийн судалгаа, хөрсний судалгаа, шинжилгээг Монгол улсын стандарт шаардлагад нийцүүлэн, хаягдлын далангийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. Төслийн хүчин чадал, ерөнхий мэдээллийг дор үзүүлэв.

Жилд боловсруулах хүдрийн хэмжээ: 60.0 мян.тн (13.2 тн/цаг)

Хаягдал дамжуулах хүчин чадал: 60.0 мян.тн (13.2 тн/цаг)

Хаягдалд агуулагдах натрийн цианидын агуулга 1-2мг/л

Үйлдвэрээс гарах хаягдлын хатуулаг: 85-88 %

Уурхайн ашиглах хугацаа: 3 жил

Хаягдлын овоолгын бүтэц:

Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдал хадгалах талбайг тусгай зөвшөөрлийн талбайд, үйлдвэрийн зүүн талд 300 м зайд барьж байгуулахаар төлөвлөсөн. Хаягдлын овоолго нь хойноосоо урагш чиглэлд 0.15 км, зүүнээс баруун тийш 0.15 км хэмжээтэй байна. Хаягдлын овоолго байрлуулах газар түүхийн дурсгалт зүйлс, дэд бүтцийн барилга байгууламж байхгүй байна. Анхдагч даланг чулуу, хөрс хуулалт, хайрга дайрга, элсний холимог материалыг ашиглан барьж байгуулах ба хаягдлаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэн хаягдлын аж ахуйн талбайн ёроолд хөрсөнд үл нэвчүүлэх 1.5мм-н зузаантай HDPE геомембран дэвсгэрийг дэвсэнэ.

Сонгосон талбайн өнгөн хөрсийг хуулсны дараа гадаргыг бульдозероор түрж тэгшлэн, уг тэгшилсэн гадаргуу дээр ус үл нэвчүүлэх зорилгоор шаврын үеийг 40 см зузаантайгаар жигд тараан индүүдэж, түүн дээр тусгай зориулалтын HDPE геомембран нийлэг дэвсгэрийг дэвсэнэ. Уг дэвсгэрийг гэмтэхээс хамгаалж дээр нь 20 см зузаантай нарийн хайрган үеийг бэлдэнэ.

Хоргүйжүүлэх процесс:

Үйлдвэрийн уусгалтын циклээс гарсан хаягдал зутанг хоргүйжүүлэх цех рүү насосоор шахна. Хоргүйжүүлэх цехэд цианид задлах процесс 2 үе шаттай явагдана. Цианидыг “Агаар/SO2“ аргаар задална. Үүнд метабисульфит натри хэрэглэх ба зэсийн сульфатыг катализатор болгон нэмж өгнө. Цианидыг задалсны дараа 1 үе шат бүхий хүнцэл тунадасжуулах процесс явагдах ба төмрийн сульфат нэмж өгнө. Тунадасжуулах төхөөрөмжийг уурхайгаас ирж байгаа хүдэр дэх хүнцлийн агуулга зохих түвшингээс дээш гарсан тохиолдолд ажиллуулна. Хоргүйжүүлэлтээс гарсан зутанг усгүйжүүлэх хэсэгт шүүн шахаж хуурай хаягдал хаях ба хаягдал дахь цианидын болон хүнцлийн хэмжээ 1-2 мг/л-ээс бага байна.

## 1.5 Дэд бүтэц

### 1.5.1.Цахилгаан хангамж

Тус уурхай нь Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын төвөөс хойд зүгт 20 км зайд байрладаг. Энэхүү төслийн хүрээнд тус ордыг 3-н жилийн хугацаанд ашиглах хэдий ч ордын нөөц цаашид өсөх боломжтой, далд уурхайн байнгын цахилгаан хэрэглэгчидтэй, мөн уурхайгаас олборлосон хүдрийг гравитаци, уусгалтын хосолсон технологиор баяжуулах тул уурхай болон баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг найдвартай эрчим хүчнээс хангах зорилгоор Эрдэнэдалай сумаас 20 км 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж эрчим хүчээр хангахаар төлөвлөсөн.




Зураг 9. Цахилгаан дамжуулах шугам

Уурхай болон баяжуулах үйлдвэрийн хэрэглэгчид нь бага хүчин чадалтай тоног төхөөрөмжүүд байгаа тул 2-р зэрэглэлийн хэрэглэгчдэд хамаарагдана. Тооцооны бүрэн чадлыг үндэслэн баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор 35/0.4 кВ-ын 2х1150 кВА-ын чадалтай ТМ-2х1150-35/0.4 маркийн хүчний трансформаторыг шинээр байгуулан ажиллуулахаар тооцоог хийж гүйцэтгэлээ. ТМ-2х1150 маркийн трансформатор нь түгээмэл хэрэглэгддэг, өндөр талдаа 35 кВ-ын агаарын оролттой, нам талдаа 0.4 кВ-ын кабель гаргалгаатай иж бүрэн трансформаторын дэд станцыг баяжуулах үйлдвэрийн дэргэд барьж байгуулахаар төлөвлөлөө.




Зураг 10. ТМ 2х1150-35/0.4 төрлийн иж бүрэн трансформаторын дэд станцын зураг

Уурхайд цахилгаан эрчим хүчний доголдол үүссэн үед эрчим хүчээр хангах зорилгоор дараах дизель цахилгаан үүсгүүрүүдийг нөөцөд байлгана.



Фото зураг 1. BF-C140 маркийн дизель генератор



Фото зураг 2. BF-C275 маркийн дизель генератор

1.5.2. Дулаан хангамж

Шарга-Овоогийн алтны үндсэн ордын ил уурхай нь жилд 210 хоног, далд уурхай нь жилд 300 хоног ажиллах ба өвлийн улиралд уурхайн барилга байгууламжуудыг нам даралтын уурын зуухнаас шаардлагатай дулаанаар хангах болон ажилчдын амрах байр, оффис, гал тогоо, ариун цэврийн өрөө, угаалгын газрыг хэрэглээний халуун усаар хангахаар төлөвлөсөн. Уурын зуухны сарын хэрэглээнд 10 тн нүүрс түлэх шаардлагатай гэж үзвэл жилд буюу 12 сарын хугацаанд 120 тн нүүрс хэрэглэнэ. Шаардлагатай нүүрсийг Шарга-Овоо, Хөөтийн нүүрсний уурхайгаас худалдаж авахаар төсөлд тусгасан.

1.5.3. Усан хангамж

Ажиллагсдын унд ахуйн хэрэгцээний ус, уурхайн технологи, баяжуулах үйлдвэрийн технологид шаардлагатай цэвэр усыг өөрийн 2 гүний худгаас хангана. Далд уурхайн ашиглалтын явцад шүүрлийн ус илэрвэл хуримтлуулан уурхай ба баяжуулах үйлдвэрийн технологийн усны хэрэглээнд хэрэглэх боломжтой.

Хүснэгт 8. Худгийн координат

| | Уртраг | Өргөрөг | Худгийн ундарга |
|---|---|---|---|
| Худаг-1 | 104° 57' 52.91"E | 46° 10' 55.86"N | 3 л/сек |
| Худаг-2 | 104° 58' 12"E | 46° 11' 03"N | 2.5 л/сек |




Зураг 11. Худгийн байршил

Усны тооцоо:

Унд ахуйн усны хэрэглээ:

Төслийн хугацаанд нийт 170-202 хүн ажиллахаар төлөвлөв. Уурхайг ашиглах эхний жилд 170 ажилчин, 2 дахь жилд 198 ажилчин, 3 дахь жилд уурхайд уулын ажлын хэмжээ болон бүтээгдэхүүн гаргалттай холбогдуулан 202 хүн дунджаар ажиллахаар тооцоолов. Хөдөлмөрийн хуваарийн дагуу 14:14 уртын ээлжээр ажиллавал уурхай дээр 101 ажилтан байнгын байрлаж ажиллана.

(* - БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт –“Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон байр, ус халаагууртай, усанд орох онгоцтой орон сууц – 150л/хоног/хүн)

Хүснэгт 9. Ахуйн ундны усны тооцоо

| Олборлолтын үе | Норм, л/хоног | Хүний тоо, ш | Усны зарцуулалт | | |
|---|---|---|---|---|---|
| | | | м3/хоног | Жилд ажиллах хоног | м3/жил |
| 1-р жил | 150л/ажилтан | 170 | 25.5 | 210 | 5355.0 |
| 2-р жил | 150л/ажилтан | 198 | 29.7 | 300 | 8910.0 |
| 3-р жил | 150л/ажилтан | 202 | 30.3 | 300 | 9090.0 |

Зам талбайн усны хэрэглээ

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 7 долоо хоног тутамд явуулна (зөвхөн өдрийн цагаар). Автоцистерн тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай

тохиолдолд замд хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Тоос дарах ажлыг тоноглосон нэг усалгааны машин гүйцэтгэнэ.

БОАЖНХЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар баталсан ус хэрэглээний нормын дагуу 1 м2 зам талбайг 2.0 л усаар усална гэсэн нормоор усны хэрэгцээг тодорхойлбол.

Хүснэгт 10. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ

| Ашиглалтын жил | Жилд услах зам, м2 | Норм, л | 7 хоногт услах тоо | Жилд услах тоо | Ашиглах ус, м3/жил |
|---|---|---|---|---|---|
| 1-р жил /210 хоног ажиллана/ | 3600.0 | 2.0 | 1 | 30 | 216 |
| 2-р жил /300 хоног ажиллана/ | 3600.0 | 2.0 | 1 | 43 | 309.6 |
| 3-р жил /300 хоног ажиллана/ | 3600.0 | 2.0 | 1 | 43 | 309.6 |
| Нийт | | | | | 835.2 |

БОНХАЖ-ын сайдын 2015.07.30 өдрийн А/301 тоот “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай” тушаалын 2-р хавсралтанд 1 тн алт уусган баяжуулахад 3.0 м3 ус хэрэглэнэ гэж нормчилсон байна.

Технологийн ус эргүүлэн ашиглалт 90.0% байна.

Хүснэгт 11. Технологийн ус хэрэглээ

| Олборлолтын үе | | | |
|---|---|---|---|
| | 1-р жил | 2-р жил | 3-р жил |
| Ил уурхайн хүдэр олборлох хэмжээ, мян.тн | 53.11 | 51.23 | |
| Далд уурхайн хүдэр олборлох хэмжээ, мян.тн | | | 30.27 |
| Усны хэрэглээ мян.куб | 159.33 | 153.69 | 90.81 |
| 90% нь эргэлтийн ус | 143.4 | 138.3 | 81.73 |
| 10 % нь цэвэр ус | 15.93 | 15.39 | 9.08 |

Нийт технологийн нэмэлт усны хэрэглээнд 40.04 мян.м3 ус ашиглана.

Биологийн нөхөн сэргээлт

Төсөл хэрэгжүүлэгч нь Шарга-Овоо нэртэй алтны үндсэн ордын нөөцийг бүрэн олборлосны дараа уурхайн ашиглалтыг зогсоож хаахаар шийдвэрлэсэн тул тус уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг олборлолт дууссаны дараа эхлүүлэх боломжтой юм1.

Уулын ажлын хувьд ТМ агуулах, ил уурхай, хөрсний овоолго, гадаргуугийн зам, барилга байгууламж, баяжуулах үйлдвэр зэрэг нийт 34.2 га талбай эвдрэлд өртөнө2.

Төслийн ил уурхайн ашиглалтын 3 жилийн хугацаанд нийт 34.2 га талбай нөлөөлөлд өртөх ба техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг уурхайн ашиглалтын 2 дахь жилээс эхлэн хийх юм. Уурхайг бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээх бөгөөд эвдрэлд өртөх нийт 34.2 га (342000.0 м2) талбайд говь-хээрийн бүсийн бэлчээрийн ургамлын байгалийн бүрэлдэхүүнд тохирсон олон наст өвслөг ургамалыг тарьж биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.

Нөхөн сэргээлтэнд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 11-р хавсралтын дагуу олон наст ургамлаар нөхөн сэргээсэн талбайг 4 л/м3 нормоор услахаар тооцлоо. Усалгааг 7 хоногт 1 удаа хийнэ.

БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-301 дугаар тушаалаар батлагдсан нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу тарилт, суулгалт хийсний дараа нөхөн сэргээлтэд тарьсан ургамлыг бие даан ургах чадвартай болтол нь усалж арчилна гэж заасан байдаг. Усалгааг газрын гадаргын налуу, хэлбэржилт, байрлал, цаг уурын нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хийх ба ялангуяа нөхөн сэргээлтийн эхний жилд хөрсний чийгийн горимыг барихын тулд хийх усалгааны тоо 7 хоногт 1 удаа, сард 4 удаа, жилд 15 удаа байна.

Хүснэгт 12. Биологийн нөхөн сэргээлтийн ус хэрэглээ

| Шимт хөрсөөр хучилт эхлэх үеэс тоолсон хугацаа | 1-р жил | 2-р жил | 3-р жил | 4-р жил |
|---|---|---|---|---|
| Жилд нөхөн сэргээлт хийх талбай, мян.м2 | - | 114.0 | 114.0 | 114.0 |
| Нөхөн сэргээсэн талбайг 4 л/м2 усаар усална | | 4 | 4 | 4 |
| Хоногт усалгаанд шаардагдах ус, м3 | - | 456.0 | 456.0 | 456.0 |
| Жилд хэдэн удаа услах | - | 15 | 15 | 15 |
| Жилд усалгаанд шаардагдах ус, м3 | - | 6840.0 | 6840.0 | 6840.0 |

1 ТЭЗҮ 222-р хуудас

2 ТЭЗҮ 222-р хуудас

| | |
|---|---|
| Нийт | 20520.0 |

Нийт усны хэрэглээ

Төслийн усны хэрэгцээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм" болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн төсөлд үндэслэн тооцоход:

Хүснэгт 13. Нийт усны тооцоо

| | Олборлолтын үе | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 1-р жил | 2-р жил | 3-р жил | 4-р жил | 5-р жил |
| Ил уурхайн хүдэр олборлох хэмжээ, мян.тн | 53.11 мян.тн | 51.23 мян.тн | - | - | - |
| Далд уурхайн хүдэр олборлох хэмжээ, мян.тн | - | - | 30.27 мян.тн | - | - |
| Баяжуулах усны хэрэглээ мян.куб | 159.33 мян.м3 | 153.69 мян.м3 | 90.81 мян.м3 | - | - |
| 90% эргэлтийн сан, мян.куб | 143.4 | 138.3 | 81.73 | - | - |
| 10% цэвэр ус сэлбэлт, мян.куб | 15.93 | 15.39 | 9.08 | - | - |
| Ахуйн усны хэрэглээг гүний худгаас хангана, мян.куб | 5.355 мян.м3 | 8.91 мян.м3 | 9.09 мян.м3 | - | - |
| Зам талбайн усалгаа мян.куб | 0.216 мян.м3 | 0.3096 мян.м3 | 0.3096 мян.м3 | - | - |
| Ил уурхайн биологийн нөхөн сэргээлт 34.2 га хамарна. Мян.куб | - | 6.84 мян.м3 | 6.84 мян.м3 | 6.84 мян.м3 | - |
| Нийт /мян.м3/ | 21.5 мян.м3 | 31.45 мян.м3 | 25.32 мян.м3 | 6.84 мян.м3 | - |
| Худгийн ундарга | 5.5 л/сек<br>173.448 мян м3/жил | | | | |

Жилд 21.5 мян.м3 – 31.45 мян.м3 орчим усны хэрэглээ тооцогдож байгаа бөгөөд 2 худгийн ундарга жилд 173.448 мян.м3/жил тул хүрэлцээтэй байна.

Хаягдлын сангийн байгууламж

Хаягдлын аж ахуйн байгууламжийг алтны хүдэр боловсруулах үйлдвэрээс урд зүгт 500м зайд байгуулахаар төлөвлөсөн. Хаягдлын санд ирэх хаягдлын 85%-ийг хаягдал, 15% ус байхаар тооцоолсон. Хаягдал нь хуурай тул автосамолаар зөөж хаягдана. Хаяглын санд 4 жилийн хугацаанд хуримтлагдах нийт хаягдлын ойролцоо хэмжээ 9500 м3 байхаар тооцов.3




Зураг 12. Хаягдлын сангийн ерөнхий план зураг

Ил уурхайн талбайд орох хур тунадасны хэмжээг карьерын хамгийн их талбайтай байх үеэр тооцно. Үүнийг дараах томьёогоор тооцдог.

$Y = L \times B \times X \times \beta$

Энд: L - Карьерын урт, м

B - Карьерын өргөн, м

X - Тухайн талбайд хоногт орох хур тунадасны хамгийн их хэмжээ, м. X=0.04 м

β - Карьер доторх урсцын итгэлцүүр, Скабалановичоор β=0.4

Хүснэгт 14. Уурхайд хур тунадсаар орж ирэх усны хэмжээ

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Тэмдэглэгээ | Ил уурхай №1 | Ил уурхай №2 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Карьерын урт | м | L | 277 | 350 |
| 2 | Карьерын өргөн | м | B | 100 | 83 |
| 3 | Хоногт орох хур тунадасны хамгийн их хэмжээ | м | X | 0.04 | 0.04 |

3 Хаягдлын байгууламжийн ажлын зургийн тайлан, /хуу-17/

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Карьер доторх урсын итгэлцүүр | - | b | 0.4 | 0.4 |
| 5 | Карьерт орох хур тунадасны хэмжээ | м³/хон | Y | 443.2 | 464 |
| 6 | | м³/цаг | Y | 18.5 | 19.3 |
| 7 | | м³/мин | Y | 0.31 | 0.32 |
| 8 | | м³/сек | Y | 0.005 | 0.005 |

1.5.3.Төслийн барилга байгууламж

1.5.3.1. Ажиллагсдын байр болон уурхайн захиргаа

Уурхай болон баяжуулах үйлдвэрийн захиргааны байр: Захиргааны барилга нь үйл ажиллагааны хэсэг, гүйцэтгэх удирдлага, дэмжлэг үзүүлж ажиллах хэсэг, талбайд ажиллаж буй ажилтнууд сууж ажиллах зориулалттай хэсгүүд байна. Тус барилгыг оффист шаардлагатай бүхий л тоноглолоор тоноглох ба төслийн үйл ажиллагааг удирдан ажиллана.

Тус барилга нь нийтдээ 200 м2 талбайтай, дотоод зохион байгуулалтын хувьд инженер ахлах ажилтнуудад зориулсан өрөө, уулзалтын өрөө, гал зуух хооллох өрөө, номын сан бичиг, баримтын өрөөнүүдтэй.

Ажиллагсдын байр: Уурхайн ажиллагсдын байр нь дээр дурдсан хүний нөөцөд хамрагдах нийт ажилчид болон гэрээт байгууллагуудын ажилчид байрлана. Төслийн талбай дахь кемп нь 100-150 хүн оршин суух багтаамжтай тохилог гэр, ариун цэврийн өрөө, душ мөн ажилчдын чөлөөт цагийн танхим биллиард, теннис, бялдаржуулах өрөө, сагсан бөмбөг, гар бөмбөгийн зориулалтын талбай, 120-150 хүн хооллох тохилог гал тогоо зэрэг хүн ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэхээр төлөвлөсөн. Уурхай дээр эрүүл мэндийн урьдчилсан үзлэг хийх, зөвлөгөө өгөх, анхны тусламж үзүүлэх эмийн сан бүхий цэг, эмчийн хувьд уурхай дээр орон тооны 1 эмч ажиллана.

Засварын газар

Уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь уулын механик тоног төхөөрөмж, авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Тус уурхайн засварын газар нь уурхайн тосгоны зүүн урд талд байрлах ба дараах бүрэлдэхүүнтэй байна. Энд:

Уурхайн тоног төхөөрөмжийн агрегат ба автомашины засвар, техник үйлчилгээний хэсэг

Механик цех

Материал, сэлбэгийн агуулах

Автомашины граж

Эдгээр төхөөрөмжүүдийг сэндвич барилгад байрлуулах ба дэргэд нь автомашин, утгуурт ачигч, бульдозер зэргийн засвар хийх боломжтой зориулалтын зарим нэг тоног төхөөрөмжөөр тоноглосон сэндвич барилга барьж байгуулна.




Зураг 13. Засварын газрын схем зураг

1.5.3.3 Түлш дулаан хангамж, ШТС

Шарга-Овоогийн алтны үндсэн ордын ил уурхай нь жилд 210 хоног, далд уурхай нь жилд 300 хоног ажиллах ба өвлийн улиралд уурхайн барилга байгууламжуудыг нам даралтын уурын зуухнаас шаардлагатай дулаанаар хангах болон ажилчдын амрах байр, оффис, гал тогоо, ариун цэврийн өрөө, угаалгын газрыг хэрэглээний халуун усаар хангахаар төлөвлөсөн. Уурын зуухны сарын хэрэглээнд 10 тн нүүрс түлэх шаардлагатай гэж үзвэл жилд буюу 12 сарын хугацаанд 120 тн нүүрс хэрэглэнэ. Шаардлагатай нүүрсийг Шарга-Овоо, Хөөтийн нүүрсний уурхайгаас худалдаж авахаар төсөлд тусгасан.

Шатахуун түгээх станцын эргэн тойрон, үйлдвэр болон уулын засварын байруудад гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, мөн материал асгарахад хэрэглэх ижил төстэй багаж хэрэгслүүдийг хялбар хүрч болох хэд хэдэн газарт байрлуулна. “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангах шаардлага”, норм ба дүрэм, стандарт, “Шатах тослох материал хадгалах тээвэрлэх” болон “Шатахуун түгээх станцад тавигдах шаардлага” стандарт, норм, “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, дүрмийн хүрээнд үйл ажиллагааг явуулах ба холбогдох журам, заавар, стандартыг баримтална. Галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайд стандартын дагуу галын сарай, иж бүрдлүүдийг байрлуулна.

1.5.3.4 Уурхайн бусад обьектууд

Далд уурхайн тэсрэх бодисын болон тэсэлгээний хэрэгслийн хагас далд агуулахыг ил уурхай №2-оос зүүн урд зүгт 0.4 км зайд барьж байгуулна. Тэсрэх бодисын 20 тонны багтаамжтай 1 ширхэг контейнер, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зориулалт бүхий 20 тонны багтаамжтай 1 ширхэг контейнер агуулах, тэсэлгээний ажилд бэлтгэх зориулалттай 10 тн-ын контейнер тус тус байна. Тэсрэх материалын агуулахыг зэвсэглэсэн гэрээт харуул хамгаалалтын ажилтнууд хамгаална.

Сэлбэг материалын агуулахыг 40 тн багтаамжтай контейнерт байршуулах бөгөөд зарим овор ихтэй тоног төхөөрөмж, машин механизмын сэлбэгийг зориулалтын талбайд хадгална.

Нэвтрэх байр: Нэвтрэх байр нь аюулгүйн төв цэг юм. Энэ байранд харуул хамгаалалтын хэсэг, аюулгүй ажиллагааны сургалтын алба, хяналтын хэсгүүд байрлана. Шинээр ирсэн зочид болон бүх

ажилчид тус байраар орж шалгуулан, анхан шатны сургалтад хамрагдсаны дараа нэвтэрч орох эрхтэй болдог.




Зураг 14. Нэвтрэх байрны байгуулалт

Далд уурхайн дохиолол холбоо: Уурхайн дор дурдсан цэгүүдэд богино долгионы станц тавигдсан байхаар тусгалаа. Энд:

Босоо гол амны эхлэл ба төгсгөлд /2 ш/

Далд уурхайн зэрэг ашиглагдах түвшин бүрд /2 ш/

Далд уурхайн техникийн операторуудад

Инженер техникийн ажилчдад

Үйлдвэрийн байр, дэд бүтцийн хэсгүүд, шаардлагатай байршлуудад богино долгионы станц ашиглана. Богино долгионы холбооны хэрэгслийн тоо бүртгэл, техникийн бэлэн байдлыг диспетчер буюу цахилгааны инженер хангаж ажиллана.

1.5.3.5 Химийн бодисын агуулах

Урвалж бодисын агуулахын үйл ажиллагаа нь “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах” ерөнхий шаардлага MNS 6458:2014, “Химийн хорт бодисын шошго, тэмдэглэгээ” MNS 5029:2001 стандартуудыг мөрдлөг болгон аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

Урвалж бодисын агуулахыг үйлдвэрийн дэргэд барьж байгуулахаар төлөвлөсөн ба гадуураа торон хашаагаар тусгаарлагдсан тусгай хадгалах байгууламж юм. Агуулахыг хоёр хэсэгт хувааж, химийн онцгой хортой бодис болох натрийн цианидыг бусад үл зохицох химийн бодисуудаас тусгаарлан, тусдаа хашаанд хадгална.

Уг байгууламжийн барилгын гол бүтэц, шал хана химийн зохих хамгаалалттай байна. Байшингийн хана тааз нь урвалжаас үүссэн тоос, уур манан тогтохооргүй, угааж цэвэрлэхэд хялбар, гөлгөр гадаргуутай хийх ба шал нь асгарсан шингэн урвалж, угаасан ус урсахад зориулсан сувагтай, налуу хийгдсэн, цуглуулах тосгуууртай байх бөгөөд саармагжуулах боломжтой байна. Мөн асгаралтаас хамгаалах далан, шингэн хуримтлуулах суваг (зумп) болоод асгаралтын үед авах арга хэмжээнд шаардлагатай багаж хэрэгсэл, төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байна.

Баяжуулах үйлдвэрийн дэргэд байрлах урвалж бодисын агуулахын нийт багтаамжийг 160тн багтаамжтай байхаар төлөвлөсөн бөгөөд баяжуулах үйлдвэрийн хэрэгцээнд бодис тус бүрийг

